

**ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН ХОРООНЫ  
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**  
*2023 оны 11 дүгээр сарын 22-ны өдөр, Лхагва гараг*

*Хуралдааны тэмдэглэлийн агуулга*

*Хуралдааны товч тэмдэглэл:* 1-3

*Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:* 4-13

---

*1.Байнгын хорооны даргыг сонгох тухай* 5

*2.“Төрөөс мөнгөний бодлогын талаар 2024 онд баримтлах үндсэн чиглэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Монголбанк 2023.09.25-ны өдөр ирүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/* 5-13

**Монгол Улсын Их Хурлын 2023 оны намрын ээлжит чуулганы  
Эдийн засгийн байнгын хорооны  
11 дүгээр сарын 22-ны өдөр /Лхагва гараг/-ийн  
хуралдааны товч тэмдэглэл**

Эдийн засгийн байнгын хорооны дарга Ц.Цэрэнпунцаг ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 18 гишүүнээс 10 гишүүн хүрэлцэн ирж, 55.6 хувийн ирцтэйгээр хуралдаан 14 цаг 39 минутад Төрийн ордны “Үндсэн хууль” танхимд эхлэв.

Томилолттой: Б.Баттөмөр, Н.Ганибал, Д.Өнөрболор;  
Чөлөөтэй: Д.Батлут, Х.Ганхуяг, Б.Жавхлан;

Хэлэлцэх асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ч.Хүрэлбаатарын тавьсан асуултад Байнгын хорооны дарга Ц.Цэрэнпунцаг хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн С.Чинзориг үг хэлэв.

Байнгын хорооны дарга Ц.Цэрэнпунцаг хэлэлцэх асуудлын дарааллын гурав дахь асуудал болох Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд анхны хэлэлцүүлгийг түр хойшлуулж байгааг мэдэгдэв.

**Нэг. Байнгын хорооны даргыг сонгох тухай**

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Б.Мажигсүрэн, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Эдийн засгийн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн, референт Г.Баярмаа, А.Хонгорзул нар байлцав.

Улсын Их Хурлын гишүүн, Улсын Их Хурал дахь Монгол Ардын намын бүлгийн дарга Д.Тогтохсүрэн Улсын Их Хурлын гишүүн Ц.Цэрэнпунцагийг Байнгын хорооны даргад нэр дэвшүүлж байгаа талаар танилцуулав.

Танилцуулга болон нэр дэвшигчтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

**Ц.Цэрэнпунцаг:** Эдийн засгийн байнгын хорооны даргаар Улсын Их Хурлын гишүүн Цэдэндамбын Цэрэнпунцагийг сонгохыг дэмжжэ гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9  
Татгалзсан: 2  
Бүгд: 11  
81.8 хувийн саналаар дэмжигдлээ.

*Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн М.Оюунчимэг Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.*

*Уг асуудлыг 14 цаг 45 минутад хэлэлцэж дуусав.*

***Хоёр. “Төрөөс мөнгөний бодлогын талаар 2024 онд баримтлах үндсэн чиглэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Монголбанк 2023.09.25-ны өдөр ирүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/***

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Монголбанкны Дэд ерөнхийлөгч Б.Лхагвасүрэн, мөн банкны Ерөнхий эдийн засагч Д.Ган-Очир, Төлбөр тооцооны газрын захирал Э.Анар, Мөнгөний бодлогын газрын захирал Б.Баярдаваа, Нөөцийн удирдлага, санхүүгийн зах зээлийн газрын Санхүүгийн зах зээлийн хэлтсийн захирал О.Одгэрэл нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Б.Мажигсүрэн, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Эдийн засгийн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн, референт Г.Баярмаа, А.Хонгорзул нар байлцав.

“Төрөөс мөнгөний бодлогын талаар 2024 онд баримтлах үндсэн чиглэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Эдийн засгийн байнгын хорооны танилцуулгыг ажлийн хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Ч.Ундрам танилцуулав.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Т.Доржханд, М.Оюунчимэг, Ж.Ганбаатар нарын тавьсан асуултад ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Ч.Ундрам, Улсын Их Хурлын гишүүн, Эрүүл мэндийн сайд С.Чинзориг, Монголбанкны Дэд ерөнхийлөгч Б.Лхагвасүрэн, мөн банкны Ерөнхий эдийн засагч Д.Ган-Очир нар хариулж, тайлбар хийв.

*Зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.*

**Ц.Цэрэнпунцаг:** 1.Тогтоолын төсөлд доор дурдсан агуулгатай 2 дахь заалт нэмэх:

“2.Доор дурдсан арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар /Л.Оюун-Эрдэнэ/, Монголбанк /Б.Лхагвасүрэн/, Санхүүгийн зохицуулах хороо /Д.Баярсайхан/-нд тус тус даалгасугай:

1/Орон сууцны ипотекийн хөтөлбөрийг Засгийн газар шилжүүлэн авах хүртэлх хугацаанд хөтөлбөрийн тасралтгүй байдлыг хангаж, зээлийн эргэн төлөлтөөс санхүүжүүлэх;

2/Орон сууцны ипотекийн хөтөлбөрийн хүрээнд олгох зээлийн нийт эх үүсвэрийг нийслэл, орон нутагт тэгш, хүртээмжтэй хуваарилах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 7  
Татгалзсан: 3  
Бүгд: 10  
70.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах танилцуулгыг ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Ч.Ундрам Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

*Уг асуудлыг 15 цаг 13 минутад хэлэлцэж дуусав.*

Байнгын хорооны хуралдаанаар 2 асуудал хэлэлцэв.

*Хуралдаан 34 минут үргэлжилж, 18 гишүүнээс 12 гишүүн хүрэлцэн ирж, 66.6 хувийн ирцтэйгээр 15 цаг 13 минутад өндөрлөв.*

**Тэмдэглэлтэй танилцсан:**  
ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН  
ХОРООНЫ ДАРГА

Ц.ЦЭРЭНПУНЦАГ

**Тэмдэглэл хөтөлсөн:**  
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ  
ХӨТЛӨХ АЛБАНЫ  
ШИНЖЭЭЧ

Д.ОТГОНДЭЛГЭР

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2023 оны 11 дүгээр сарын 22-ны өдөр,  
Лхагва гараг  
Төрийн ордон “Үндсэн хууль” танхим  
11 цаг 15 минут.

### ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

**Ц.Цэрэнпунцаг:** Байнгын хорооны гишүүдийн энэ өдрийн амгаланг айлтгая. Ингээд та бүхэнд өнөөдөр гишүүдийнхээ ирцийг танилцуулъя.

Баттөмөр гишүүн гадаадад томилолттой ажиллаж байна. Ганибал гишүүн орон нутагт ажиллаж байна. Бусад нь ирсэн байна.

Өнөөдрийн хуралдаанд гишүүдийн 55.6 хувь нь хүрэлцэн ирж, ирц бүрдсэн тул Эдийн засгийн байнгын хорооны 2023 оны 11 дүгээр сарын 22-ны өдрийн хуралдааныг нээснийг мэдэгдье.

Байнгын хороогоор өнөөдөр хэлэлцэгдэх асуудлуудыг танилцуулъя.

Нэгдүгээрт, энэ 7 хоногийн хэлэлцэх асуудлын тов дараалалд бусад гэсэн асуудлын хүрээнд орсон Байнгын хорооны даргыг сонгох тухай асуудал.

Хоёр. “Төрөөс мөнгөний бодлогын талаар 2024 онд баримтлах үндсэн чиглэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл. Монголбанк 9 сарын 25-ны өдөр ирүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг.

Гурав. Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд. Оюунчимэг гишүүн тэргүүтэй 4 гишүүн. 22 оны 4 сарын 20-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн анхны хэлэлцүүлэг гэсэн 3 асуудал хэлэлцэхээр товлогдсон байна.

Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсгийн ахлагч Улсын Их Хурлын гишүүн эрүүл мэндийн сайд С.Чинзориг таныг хэлэлцэх асуудалтай холбоотойгоор хуулийн төслийнхөө талаар санал хэлнэ үү. Чинзориг сайдын микрофоныг нээе.

**С.Чинзориг:** Банк бус санхүүгийн байгууллагын тухай хуулийн шинэчилсэн найруулгын анхны хэлэлцүүлэг бэлтгэх ажлын хэсэг өчигдөр хуралдсан. Тэгээд нэгдүгээрт ирц жаахан тааруу байсан.

Хоёрдугаарт бас дахиж 7 хоног анхныхаа хэлэлцүүлгийг, зарчмын зөрүүтэй саналуудыг дахиж бас нягталж харъя гээд энэ гишүүд, ажлын хэсэг шийдсэн учраас ирэх 7 хоногийн 1 дэх өдөр ажлын хэсгээ хуралдуулахаар товлосон.

Тэгэхээр энэ өнөөдрийн Байнгын хорооны хэлэлцэх асуудлын төлөвлөгөөнөөс энэ хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг хэлэлцэх асуудлаас хасуулах саналтай байна. Банк бус, өөрийн чинь өргөн барьсан юм байна лээ шүү дээ.

**Ц.Цэрэнпунцаг:** Банк бусын хуулийг өнөөдрийн хэлэлцэх асуудлаас хаслаа. Хэлэлцэх асуудал дээр өөр саналтай гишүүд байна уу. Хүрэлбаатар сайд микрофоныг өгье.

**Ч.Хүрэлбаатар:** Хөрөнгө оруулалтын хуулийг хэзээ хэлэлцэж шийдвэрлэж өгөх вэ.

**Ц.Цэрэнпунцаг:** Хүрэлбаатар сайд тантай түрүүчийн 7 хоногт ярьсан, яриад Даргын дэргэдэх зөвлөл дээр ярилцаад бусад гэдэг асуудалд оруулсан шүү дээ бид нар. Тэгэхээр маргааш орох байх. Бусад гэдэг асуудал дээр Хөрөнгө оруулалтын хуулийг оруулаад тавьсан байгаа. Тэгэхээр тэрийг Хөрөнгө

оруулалтын хууль бараг чуулганаар хэлэлцэх ёстой шүү дээ. Байнгын хороогоор хэлэлцэх эсэх нь явчихсан, чуулганаар хэлэлцэх эсэх нь орох ёстой. Маргаашийн чуулган дээр орох байх аа гэж бодож байна.

Өөр хэлэлцэх асуудал дээр саналтай гишүүд байхгүй тул хэлэлцэх асуудалдаа орё.

**Хэлэлцэх асуудал нэг, Байнгын хорооны даргыг сонгох тухай асуудлыг хэлэлцэж эхэлье.**

Улсын Их Хурлын гишүүн Монгол Ардын намын бүлгийн дарга Д.Тогтохсүрэн таныг танилцуулгыг хийхийг урьж байна. Тогтохсүрэн даргын микрофоныг нээе.

**Д.Тогтохсүрэн:** Баярлалаа. Эдийн засгийн байнгын хорооны гишүүдийн өдрийн амгаланг айлтгая. Улсын Их Хурлын Байнгын хорооны даргын бүрэн эрхийн хугацаа 1 жил байна гээд хуультай. 1 удаа улируулан сонгож ажиллуулж болно гэсэн ийм хуультай. Энэ хуулийн дагуу Байнгын хорооны даргын эхний 1 жилийн хугацаа дууссан. Энэтэй холбогдуулаад Улсын Их Хурал дахь олонхын бүлгээс Улсын Их Хурлын гишүүн Цэдэндамбын Цэрэнпунцагийг Эдийн засгийн байнгын хорооны даргаар үргэлжлүүлэн ажиллуулах саналыг оруулж байгаа юм.

Цэрэнпунцаг даргыг бол та бүхэн мэдэх учраас товчхон танилцуулъя. 1988 онд Завхан аймгийн 10 жилийн 1 дүгээр сургууль, 97 онд Шинжлэх ухаан, техникийн их сургуулийг, 2003 онд Америкийн Нэгдсэн Улсын Доминиканы их сургуулийг тус тус төгссөн. 1999 оноос эхлээд 2020 он хүртэл хувийн хэвшилд, тэгээд тэр дотроо “Жем” группийг үүсгэн байгуулж, ерөнхийлөгчөөр нь ажиллаж байсан. 20 оноос Улсын Их Хурлын гишүүнээр сонгогдон ажиллаж байгаа. 22 оноос Эдийн засгийн байнгын хорооны даргаар ажиллаж байгаа ийм хүн байна. Ингээд

Байнгын хорооны гишүүд та бүгдийг Байнгын хорооны даргад нэр дэвшигч Цэдэндамбын Цэрэнпунцагийг дэмжиж өгөхийг хүсэж байна. Баярлалаа.

**Ц.Цэрэнпунцаг:** Байнгын хорооны даргыг сонгох тухай асуудал дээр өөр саналтай гишүүд байна уу. Алга байна.

Нэр дэвшигчээс асуулт асууж, үг хэлэх гишүүд байна уу. Алга байна.

Гишүүд асуулт асууж, үг хэлж дууслаа.

Ингээд саналын томъёоллыг та бүхэнд уншиж танилцуулъя. Эдийн засгийн байнгын хорооны даргаар Улсын Их Хурлын гишүүн Цэдэндамба овогтой Цэрэнпунцагийг нэр дэвшүүлэхийг дэмжье гэсэн өгсөн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт.

Гишүүдийн 81.8 хувь нь дэмжиж, санал дэмжигдлээ.

Санал хураалт явуулж дууслаа. Байнгын хорооны санал, дүгнэлтийг нэгдсэн хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн Оюунчимэг танилцуулна. Байнгын хорооны даргыг сонгох тухай асуудлыг хэлэлцэж дууслаа. Дараагийнхаа асуудалд орё.

14.45 цаг

**Хэлэлцэх асуудал хоёр, “Төрөөс мөнгөний бодлогын талаар 2024 онд баримтлах үндсэн чиглэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн эцсийн хэлэлцүүлгийг хэлэлцэж эхэлье.**

Чуулганы нэгдсэн хуралдааны анхны хэлэлцүүлгээр олонхын дэмжлэг авсан саналын томъёоллыг тогтоолын төсөлд нэмж тусгасан эцсийн хувилбарыг, төслийг та бүхэнд тараасан байгаа.

Төслийг Байнгын хорооны болон чуулганы нэгдсэн хуралдааны эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх ажлын хэсгийн танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн, ажлын хэсгийн ахлагч Ч.Ундрам танилцуулна. Ундрам гишүүний микрофоныг нээе.

**Ч.Ундрам:** Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Төв банкнаас боловсруулж Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн “Төрөөс мөнгөний бодлогын талаар 2024 онд баримтлах үндсэн чиглэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг 2023 оны 11 дүгээр сарын 16-ны өдөр чуулганы нэгдсэн хуралдаанаар анхны хэлэлцүүлгийг явуулж, эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Эдийн засгийн байнгын хороонд шилжүүлсэн билээ.

Ажлын хэсэг 2023 оны 11 дүгээр сарын 20-ны өдөр хуралдаж, чуулганы нэгдсэн хуралдаанаар хуулийн төслийн анхны хэлэлцүүлэг явуулах үед хуралдааны даргалагчаас өгсөн чиглэлийн дагуу төслийн заалтыг гүйцээн боловсруулж, зарчмын зөрөөтэй 1 саналыг бэлтгэлээ.

Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

“Төрөөс мөнгөний бодлогын талаар 2020, 2024 онд баримтлах үндсэн чиглэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн талаар ажлын хэсгээс гаргасан саналыг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

**Ц.Цэрэнпунцаг:** Ундрам гишүүнд баярлалаа. Ажлын хэсгийг танилцуулъя. Б.Лхагвасүрэн Монголбанкны Ерөнхийлөгч, Г.Энхтайван Монголбанкны Дэд ерөнхийлөгч, Т.Ган-Очир Монголбанкны Ерөнхий эдийн засагч, Анар Монголбанкны Төлбөр тооцооны газрын захирал, Баярдаваа

Монголбанкны Мөнгөний бодлогын газрын захирал, Одгэрэл Монголбанкны Нөөцийн удирдлага, санхүүгийн зах зээлийн хэлтсийн захирал.

Ажлын хэсгийн танилцуулгаас асуух асуулттай Улсын Их Хурлын гишүүд нэрсээ өгнө үү. Алга байна. Доржханд гишүүн, Оюунчимэг гишүүнээр тасалъя. Доржханд гишүүний микрофоныг нээе.

**Т.Доржханд:** Баярлалаа. Энэ ипотекийн зээлийн хөтөлбөрийг нэмж ямар нэгэн эх үүсвэр гаргаж санхүүжүүлэхгүй, мөнгө хэвлэхгүй, харин зээлийн эргэн төлөлтөөс одоо санхүүжүүлнэ гэдэг энэ зарчим бол зөв. Үүнийг бол дэмжиж байгаа тийм. Харин энэ 2 дахь заалт байна л даа. Орон сууцын ипотекийн хөтөлбөрийн хүрээнд олгох зээлийн нийт эх үүсвэрийг нийслэл, орон нутагт тэнцүү хуваарилна гээд. Би өөрөө ажлын хэсгийн гишүүн мөн нь бол мөн. Гэхдээ энэ 2 дахь заалт байх шаардлагагүй гэсэн ийм байр суурьтай байна л даа.

Өөрөөр хэлэх юм бол бид нар чинь ямар социалист системд амьдарч байгаа биш дээ. Зах зээлийн эдийн засагт амьдарч байгаа, цоо шинэ тогтолцоонд ороод 33 жил болчихоод одоо ингээд 50 хувийг нь тийшээ, 50 хувийг нь ийшээ гэдэг энэ бол буруу бодлого байгаа. Эдийн засгийн байнгын хорооноос ийм шийдвэр гарах нь бол зохимжгүй байх гэж бодож байна.

Зах зээл хаана байна, хаана эрэлт хэрэгцээ байна тээшийгээ бид нар мөнгөнийхөө нийлүүлэлтийг хийж байх чинь энэ чинь зарчим биз дээ. Тэгээд хаана бид нар бодлогоороо тэр бүсчилсэн хөгжил гээд бичиг баримт байж байна. Зарим газар нь хот байгуулна гээд орон сууцын хэрэгцээ шаардлага бол байна. Цахилгаан станц барих шаардлага бол байна. Зарим орон нутагт маш олон сумуудад тухайлбал ийм бодитой зах зээл байхгүй байна шүү дээ жишээ нь. Тэгвэл энийг чинь нөгөө хөшүүрдэх



механизм нь юу вэ гээд тэгэхлээр тэр чинь өөр механизм байхгүй юу. Нөгөө орон нутгийн нэмэгдэл олгоно гэдэг бодлого бол зөв шүү дээ. Олон улсад байдаг. Хэрвээ сайн багшийг байлга гэх юм бол сумдад 100 хувийн нэмэгдэлтэй бол, аймгийн төвд 50 хувийн нэмэгдэлтэй гээд юм байдаг шүү дээ.

Гэтэл энэ байшин барих энэ зээлийг ингээж тэнцүү хуваарилна гэдэг бол дэлхий дээр ийм бодлого байхгүй дээ. Манайх чинь зах зээлийн эдийн засагт шилжээд 33 жил болж байгаа. Энийгээ ингээд 50, 50 хувиар сайхан тэнцүү хуваагаад хэл амгүй ингээд явчихъя гэдэг бол энэ бол буруу байх гэсэн ийм байр суурьтай байна. Энийгээ хасах нь зүйтэй байх. Энэ дээр яг ямар үндэслэлээр ийм асуудал хөндчихсөн юм бэ гэдгийг би бас тодруулмаар байна. Баярлалаа.

**Ц.Цэрэнпунцаг:** Ажлын хэсэг Ундрэм, ажлын хэсгийн ахлагч Ундрэм гишүүн хариулъя. Ундрэм гишүүний микрофоныг нээе.

**Ч.Ундрэм:** Ажлын хэсэг дээр бид нар энэ асуудлыг ярилцах үед одоо энэ чинь 2 дахь удаагаа ажлын хэсгийн хуралдаанаар яригдаж байгаа.

Нэгдүгээрт, 2024 оны төсвийн тухай хуулийг дагалдаж гарч байгаа Улсын Их Хурлын тогтоолын төсөлд орон нутагт болон Улаанбаатарт тэнцвэртэйгээр тэнцүү бас ингээж олгох асуудал энэ тогтоол дээр гараад, ороод батлагдчихсан байгаа. Тэгээд бид нар энэ мөнгөний бодлогын үндсэн чиглэл дээр оруулж байгаа асуудал нь 2024 онд ипотекийн зээлийг Засгийн газар руу шилжүүлж гэгчихсэн ийм тогтоол гарчихсан учраас бид нар заавал одоо энэ үндсэн чиглэл дээр энэ асуудлыг хөндөж орж байгаа. Тэгээд энэ Улсын Их Хурлаас гарсан тогтоолтой уялдуулж энийг нэгдүгээрт оруулж байгаа.

Хоёрдугаарт өнгөрсөн хугацаанд олгогдсон ипотекийн зээлийг харах юм бол 80 хувь нь Улаанбаатар хотод, 20

хувь нь энэ 21 аймагт олгогдсон байгаад байгаа юм. Тэгээд 21 аймагт бол маш их хэмжээний хүсэлтүүд байгаа боловч энэ нь одоо хангалттай олгогдохгүй. Одоо Дархан, Эрдэнэтээс авхуулаад энэ томоохон хот суурин газруудад маш их хэмжээний хөрөнгө оруулалт хийгдэж, байшин барилгууд баригдаж байгаа мөртөө олгогдохгүй байгаа ийм асуудал байгаа.

Тийм учраас бид нар мөн энэ Засгийн газраас одоо хотоос хөдөө рүү шилжих ийм бодлого хэрэгжиж байгаа. Энэнтэйгээ ч гэсэн уялдуулсан гэсэн. Ядаж одоо тэнцвэртэйгээр 50 хувийг энэ 21 аймаг, хөдөө орон нутаг руу бид нар чиглүүлэх нь зүйтэй гэж ажлын хэсэг дээр ярьсны үндсэн дээр энд одоо энэ орж ирж байгаа юм.

Тэгээд энэ саналыг бүүр анхлан санаачилсан Чинзориг сайд бас саналаа тайлбарлаж бас хэлэх байх. Мөн энэ дээр бас Монголбанкнаас нэмэлт тайлбар өгөх байх.

**Ц.Цэрэнпунцаг:** Сая ажлын хэсгээс нэмэлт тайлбар өгөх үү. Өгөх шаардлагагүй бол би Доржханд гишүүний сая бас энэ одоо анхаарах ёстой зүйлээ гэж ярьж байгаа энэ тэнцүү хуваарилах гээд ингээд энэ бичиж. Энэ бас найруулгын хувьд, үгний сонголтын хувьд бас жоохон өөр, буруу сонголт болчихсон юм болов уу. Буруу ойлгогдохоор гэж ойлгоод байна. Тэгээд сая бас Ундрэм гишүүн ажлын хэсгийн ахлагчийн ярьж байгаагаар бол энийг тэнцвэртэй гэсэн үг ашиглаж, сонгож аваад явчихвал тэнцвэртэй гэдэг маань ер нь энэ яг 50, 50 хувиар тэнцүү хуваана гэдэг агуулгаараа биш. Тэр зохистой харьцааг бас барьж ажиллаж гэсэн, явах ёстой гэсэн энэ чиглэл өгч байгаа бол ийм л ойлголт гэж үзээд тэнцвэртэй гэдгээр уншаад явчихъя тэгэх үү. Доржханд гишүүний микрофоныг нээе.

**Т.Доржханд:** Үгүй ээ яах вэ яг тийм агуулгаар явж байгаа бол үг, үсгээ найруулгаа засчих хэрэгтэй байх. Би бол



Байнгын хорооны даргын тэр өнцгийг бол болж байна. Тэгвэл үнэхээр бодлого гэж байгаа юм бол тээ, хотод нэг суурьшлын бүсийг бий болгож хүн амын шилжих хөдөлгөөнийг тэнд нь үлдээнэ ээ гэдэг ийм бодлого байгаа бол дор хаяж нийт эх үүсвэрийн 50-аас доошгүй хувийг орон нутагт төвлөрүүлээч гэдэг юм уу ийм байдлаар найруулах юм бол энэ ойлгогдох нь тодорхой байхгүй юу. Үнэхээр бодлого гэж. Түүнээс ингээд сайхан тэнцүү хуваагаад хаячихъя гээд. Тэгэхлээр энэ өөрөө агуулга нь буруу байна. Тэгээд хоёрдугаарт энэ чинь яг үнэнээ хэлэхэд орон нутгийг дэмжиж болно болно.

Гэхдээ тэнд чинь нөгөө хот суурин газар чинь дэд бүтцийн хүрэлцээ нь юу байгаа билээ. Тэгээд зах зээлийн эргэн төлөх чадвар нь бас юу байгаа билээ. Би өнөөдөр бүх сумуудаар явж байна. Одоогийн байдлаар 330 сумын 90 сумдаар явж байна. Өглөө орж ирлээ. Нийт сумын иргэдийн тоо одоо 1500 болчихоод байна шүү дээ тэнд чинь. Тэгээд иргэдэд нь суурьшил байхгүй энийг тогтооё гээд тэгэх юм бол дэд бүтэц рүү нь санхүүжилт хийх ёстой. Гэтэл бүгдээрээ л.../минут дуусав./

**Ц.Цэрэнпунцаг:** Чинзориг гишүүн хариулъя. Ажлын хэсгийн гишүүн.

**С.Чинзориг:** Одоо Засгийн газраас бол энэ Улаанбаатар хотын төвлөрлийг одоо бас бууруулах гээд бодлого явуулаад байгаа. Улаанбаатар хотоос хөдөө орон нутагт шилжин очиж ажиллаж амьдарч байгаа иргэдийг дэмжих ийм бас бодлого бол явуулж байгаа. Энэ хүрээндээ ипотекийн зээлийн хүүг одоо бас тодорхой хэмжээгээр бас бууруулах энэ тэр бодлого явуулж байгаа юм.

Тийм учраас бол энэ Засгийн газраас явуулж байгаа энэ Хөдөөгийн сэргэлтийн бодлогын хүрээнд энэ ипотекийн зээлийн санхүүжилтийн эх үүсвэрийг хөдөө, орон нутагт бас нийслэлтэй бас ижил тэнцүү хэмжээгээр бас олгодог байхгүй бол болохгүй.

Одоогийн байдлаар бол Монголбанкныханы ярьж байгаагаар бол 84 хувь нь Улаанбаатар хотод, 16 хувь нь орон нутагт хуваарилагдаад байгаа юм байна лээ л дээ. Тэгээд энэ бодлого өөрчлөгдөхгүй бол энэ Улаанбаатар хотын төвлөрлийг сааруулах энэ Хөдөөгийн хөгжлийг дэмжих бодлого бол хэрэгжихгүй байна гээд. Ингээд ажлын хэсэг дээрээ ярьсан. Засгийн газартай ч бас энэ асуудал.../минут дуусав./

**Ц.Цэрэнпунцаг:** Чинзориг гишүүн нэмж цаг өгье. Нэмж гүйцээж хариулъя.

**С.Чинзориг:** Засаг дээр яригдсан санал нь бол бүр санхүүжилтийн эх үүсвэрийн 60 хувийг хөдөө орон нутагт олгожээ. 40 хувийг нь Улаанбаатарт олгожээ гэдэг хүртэл асуудал яригдаад, яригдсан юм. Тэгээд бас Ерөнхий сайд ч гэсэн бас энэ бодлогоор явах нь зүйтэй гэж Засаг дээр яригдсан. Энийг бол ажлын хэсэг дээр бид нар ярьж байгаад яахлаар жаахан Улаанбаатар хотын сонгогдсон гишүүд бас жаахан таатай бус байна гэсэн юм ярьж байгаад, сүүлдээ ер нь тэгш, хүртээмжтэй байлгах ийм бодлого л баримтлах нь зүйтэй гээд. Ажлын хэсэг дээр ярьж байгаа бид нар тэр Төсвийн тухай хууль, төсөв батлагдсантай холбогдуулан авах арга хэмжээний тогтоолд тэгш, хүртээмжтэй гэдгээр орчихсон юм.

Тэрийг ажлын хэсэг дээр ярих дээр бол тэгш, хүртээмжтэй гэдгээ тодорхой болгохгүй бол нөгөө арилжааны банкнууд хэрэгжүүлдэг учраас наадах чинь тэгээд одоо яг ижил, тэнцүү хэмжээгээр, хөрөнгө эх үүсвэр хуваарилагдана гэдэг асуудал ойлгогдохгүй дээ гэж ярьж байгаад ингээд ийм тэнцүү гээд оруулчихсан. Үүгээр байхад ер нь буруутахгүй юм байхгүй.

Тэнцвэртэй гэх юм бол энэ бол нэг их тийм бас зөв, оновчтой үг бол болохгүй. Тэнцвэртэй гэдэг бол бас тийм их оновчтой хувилбар бол болохгүй л гэж л үзэж байна.

**Ц.Цэрэнпунцаг:** Ер нь тийм энэ үгээ сонголтынхоо хувьд цөмөөрөө ярьж байгаад нэг үгээ сонгоод, томьёололдоо оруулаад явчихъя тэгэх үү. Тэнцвэртэй гэх юм уу, тэгш, хүртээмжтэй гэх юм уу. Одоо аль өнцгөөр нь ч. Ер нь хатуу тавиад, тавих бол аягүй бодит амьдрал дээр хүндрэл гарч ирэх л юм байна лээ л дээ. Аль аль ч талаас нь ярьсан. Тэгээд 50, 50 тэнцүү гэвэл бас сүүлдээ бас л нэг өнцөг гараад ирнэ. Яг бодит шаардлага нь эрэлт нь хөдөөд нь, хотод нь илүү байгаад байдаг тийм ээ. Тэгэх дээр энэ үгний сонголт дээр одоо ажлын хэсэг дээр яах вэ. Энэ чинь шууд бид нар энэ дээр одоо тэнцвэртэй гэдэг үү. Тэнцүү гэдэг чинь, тэнцүү гэдэг бол ерөөсөө 50, 50 гэсэн ойлголт биш шүү дээ ер нь.

Тэгэхээр энийгээ тэнцвэртэй гэхээр их гайгүй биш үү. Тэгэхээр энийгээ байна шүү дээ тэнцвэртэй гэдэг үг тэгж ойлгогдох уу. Тэгвэл ажлын хэсгээс одоо ямар санал байна. Тэгш хүртээмжтэй. Тэгвэл одоо энэ хуучин үүгээр юу ч байсан хураагаад, саналаа хураачихъя. За тэгье Оюунчимэг гишүүн асуултаа асууя.

**М.Оюунчимэг:** Энэ ипотекийн зээлтэй холбоотой заалтаас болоод энэ төрөөс баримтлах мөнгөний бодлого нэлээн л цаг авч байх шиг байна л даа. Энэ ганц заалт нь. Анхнаасаа л 40, 60 гэж орж ирэх нь л буруу байсан гээд би анхнаасаа эсэргүүцэж байсан. Ер нь тэгж хатуу тоо заах юм уу, хатуу ингээж тэнцүү 60, 40 гэдэг юм уу ингэх нь буруу. Аль ч талаасаа ер нь тэгээд зах зээл өөрийнхөө эрэлт хэрэгцээгээ дагаж байж л ипотек хаана илүү эрэлт хэрэгцээтэй байна, хаана илүү хүсэлт байна тэнд нь шаардлагатай байна гэдэг л тооцоо, судалгаа шинжлэх ухаанчаар хандах ёстой гэсэн байр суурьтай байгаа.

Ер нь засгийн Засгийн газар ч гэсэн энэ 2024 оны төсвийн гол зорилго бол хот, хөдөөгийн тэнцвэртэй хөгжлийг хангах зорилгоо гээд тайлбарлаад, мэдэгдээд Монгол Улсын Ерөнхий сайд

чуулганы хуралдаан дээр энийг хэлж байсан. Тэгэхээр бид ипотекийн зээл дээр бас тэнцвэртэй байдлыг хангах гэдэг утгаар нь оруулаад явчихвал төсөвтэйгөө уялдах юм болов уу гэсэн би байр суурьтай байна. Тэгээд энэ дээр өмнө нь бас сая чуулган дээр мөнгөний бодлогыг хэлэлцэж байх үед энэ гэр хороолол болон орон нутагт яг орон сууцжуулахад оролцож байгаа компаниудыг нөгөө гааль, НӨАТ-ын татвараас чөлөөлөх гэсэн заалт дагалдаж орж явж байгаа гэж би ойлгосон шүү дээ.

Гэхдээ энэ төсөвтэй дагалдаж орж ирсэн хуулиуд дээр энэ явна гэсэн. Сая нийслэлийн хуулийг хүлээгээд түр хойшлогдчихлоо гээд би ойлгоод байгаа. Тэгэхээр эртээд ажлын хэсгийн ахлагч хэлж байсан Улаанбаатар хотын гэр хороололд байгаа иргэдийг энэ ипотекийн зээлд хамруулахад 20 гаруй, 20-оос доошгүй хувийг нь зарцуулна гэсэн заалтыг бид нар бас оруулж байгаа гэж хэлж байсан. Энэ заалт хэвээрээ юу. Энэ дээр дэмжигдээгүй юм уу. Уг нь яг энэ гэр хороолол руу чиглэсэн юман дээр орон нутагт ч гэсэн яг ингээж орвол зүгээр байсан юм. Тэгээд нөгөө 650 орчим тэрбум төгрөг гэхээр эргээж төлөгдөх зээлээсээ санхүүжилтээ хийгээд яв гэсэн. Тэгээд энэ заалт орж ирж байна шүү дээ. Тэгэхээр одоо эргээж төлөгдөх зээлийн хэмжээ та эртээд Монголбанкны Ерөнхийлөгч хэлж байсан 620 орчим тэрбум төгрөгийн бололцоо байгаа гээд байсан. Энэ яг эргээж төлөгдөх зээлдээ орж байгаа юу. Ийм асуулт байна.

**Ц.Цэрэнпунцаг:** Ажлын хэсгийн 3 номер Лхагвасүрэн Ерөнхийлөгч хариулъя.

**Б.Лхагвасүрэн:** Оюунчимэг гишүүн гишүүний асуултад хариулъя. Тэгээд яах вэ бид хэд энэ 24 онд эргээж төлөгдөх эргэн төлөлтийн дүнг үзсэн. Тэгээд ерөнхийдөө бол 500 орчим бол Монголбанкны эх үүсвэр буцаж орж ирэх юм байна лээ. Яг өнөөдрийн ипотекийн

зээл бол 80 хувь нь Монголбанкны санхүүжилт, 20 хувь нь банкны санхүүжилтээр орж байгаа юм. Тэгэхлээр Монголбанкны 500 тэрбум гэж бодох юм бол банкнаас 100 гаруй тэрбум орж ирэх юм байна гээд л 620 гэсэн ойролцоо тооцоо л гарч ирж байна. 600-620 гэсэн.

Тэгэхлээр ийм эх үүсвэр л эргэж гарна. Монголбанкнаас шинэ мөнгө гарч ирэхгүй. Энэ чинь өөрөө 4.6 их наядын эргэлтийн сан үүсчхээд одоо эргэлдээд явж байгаа юм. Тийм. Ерөнхийдөө түрүүн би эхний асуулт дээр тэнцвэртэй байх уу, тэнцүү байх уу гэдэг дээр нь Монголбанкны өр манайд байгаа статистик тоо өмнө нь бол манай журам өөрөө 70, 30 гэсэн харьцаатай байя. 30 хувь нь орон нутагт олгож байя. 70 хувь нь Улаанбаатарт олгож байя гээд явж байгаа. Тэгэхдээ орон нутагтаа бол яг л 30 хувь хүрдэггүй арван зургаа, долоон хувьтай л одоо өнөөдрийг хүртэл явж ирж байгаа. Одоо ингээд Хөдөөгийн шинэ бодлого, Шинэ сэргэлт гэдгээрээ ингээд нэлээн ахиухан орон нутаг руу өгье гэдгээр орж ирж байгаа учраас бид хэд мэдээж энэ бодлого гэдгээрээ л орон нутаг руу.

Урьд нь орон нутагт тийм их орон сууц баригдаж байгаагүй. Сүүлийн үед орон нутагт орон сууцууд нэлээн их баригдаж байгаа. Яг одоо ингээд банкин дээр өнөөдөр шийдвэр авсан хүн бол өнөөдөр зээлээ авч чадахгүй байгаа шүү дээ. Зарим банкнууд дээр бүүр 6, 7 сар очирлож байгаа. Манайд ирж байгаа мэдээллээр орон нутагт байгаа очрын хугацааны юу нь 1 сар орчмоор хүлээж байна гэсэн. Одоо ингээд 11 сард байр авч байгаа хүн нь 10 сард зээлийнх нь шийдвэр гарсан ийм хүн аваад явж байгаа. Тэгэхлээр бидний яг шууд л 50, 50 гэдэг хавтгайгаар ойлгож арай бас болохгүй байгаад байгаа.

Яагаад гэвэл орон нутагт угаасаа ханачихвал одоо эх үүсвэр байгаад байдаг орон нутагт угаасаа зээлдэгч ипотекийн зээл авахааргүй болчихвол сул

чөлөөтэй нь ингээд хот руугаа бас орж ирээд гарч ирж болно л гэдэг л тийм л. Ер нь бол яг л тэгж л хэрэгжих байх л гэж бодоод байгаа юм. Яагаад гэвэл энэ зээлийг банкнууд олгож байгаа. Банк өөрөө ингээд л харилцагчаа сонгоод л олгож байгаа. Тэгээд эхний ээлжид мэдээж орон нутгаа өгөөд явж байтал угаасаа орон нутагт барилга нь өөрөө тэгээд л зах зээл нь өөрөө ханачих байх л гэж л хараад байгаа л даа байна.

**Ц.Цэрэнпунцаг:** Сая Ганбаатар гишүүн хаачив сайд. Энэ ийм байна. Энэ Төсвийн хуулийг дагаад гарсан Улсын Их Хурлын тогтоол дээр энэ агуулга тэр чигээрээ орчихсон байгаа. Тэгш, хүртээмжтэй гээд. Тийм учраас энийг цөмөөрөө хасчихъя. Тэгээд эндээс саналаа хураачихъя тэгэх үү. Хасаад би уншихъя тэгээд саналаа хураалгая тэгэх үү. Тэр нь болохгүй юу. Их Хурлын тогтоолын төсөл дээр бол яг энүүгээрээ байгаа, дагаж гарч байгаа. Та наад найруулга. Та асуултаа асуугаарай. Ганбаатар сайд асуултаа асууя.

**Ж.Ганбаатар:** Баярлалаа. Би Монголбанкныхнаас 2 асуулт асууя.

Нэгдүгээрт, Банкны тухай хууль одоо энэ 12 сарын 31-нд хэрэгжиж, хугацаа дуусаж байгаа. Тэгээд Монголбанкны Ерөнхийлөгчид тэгээд харуулаач энэ одоо 1 хувьцаа эзэмшигчид хамгийн ихдээ 20 хувь байх ёстой шүү дээ тээ. Энэ яагаад хэрэгжихгүй байна. Энийг одоо хэрэгжүүлэх талаас юу хийж байгаа юм бэ. Энэ уул нь бол бид нарын зорьсон хамгийн том бас зорилт шүү дээ. Тэгээд энэнээсээ буцаад байна гэдэг өөрөө маш харамсалтай байна тэх. Уул нь сайд болохоор жоохон үг хэлээд татаад байна. Түүнээс биш жоохон хатуу үг хэлмээр байна. Энэ бол үнэхээр, уул нь энэ чинь бид одоо энийг хийнэ гээд л бараг 2 жилийн өмнө биз дээ. 2 жил, 3 жилийн ч өмнө байна уу баталсан шүү дээ. Тэгээд Монголбанк энэ тэр одоо санаачилгатай ажилламаар байх юм.

Би энэ Монголбанкны эдийн засагчаас асууя. Энэ одоо яг бид нарт арилжааны банкнаас зээл авахад хүү хэд байгаа юм. 3 төрлийн хүү асууя. Би бизнесийн зээлийн хүү хэд байгаа юм, хэрэглээний зээлийн хүү, цалингийн зээлийн хүү ер нь хэд байгаа юм бэ. Яг энийг надад хариулж өгөөч. Хүмүүс тэгээд өөр өөр, яах вэ бизнесийн зээл янз янз гардаг л байх л даа. Ер нь тэгээд яг дунджаар хэд байгаа юм. Арилжааны банкных шүү. Арилжааны банкны зээлийн хүү асууж байгаа юм. Дараа нь тодруулъя. Баярлалаа.

**Ц.Цэрэнпунцаг:** Ажлын хэсгийн 3 номер.

**Б.Лхагвасүрэн:** Ганбаатар гишүүний асуултад хариулъя. Тэгээд 2021 онд Банкны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулаад арилжааны банк нь хувьцаат банкны хэлбэртэй байна. Тэр системийн нөлөө бүхий 5 том банк бол олон нийтэд хувьцаагаа арилжаална. Нэг ийм зарчмын санал орсон. Өшөө нэг нь бол одоо нэгж 1 хувьцаа эзэмшигчийн төвлөрлийн дээд хязгаар бол 20 хувьтай байна гээд. Тэгээд энэ дээр хоёулан дээр нь хугацаа өгсөн. Энэ 23 оны 6 сарын 30-наар арилжааны 5 том банк IPO хийгээд, нээлттэй хувьцаат компанийн хэлбэрт ороод, 473 тэрбум төгрөг ингээд босгоод олон нийтийн өмчлөлтэй ийм банкнууд болсон.

Нэгж хувьцаа эзэмшигчийн төвлөрлийн 20 хувийн хэрэгжих хугацаа энэ 23 оны 12 сарын 31-ээр байгаа. Хэрэгжих хугацаа нь 23 оны. Тэгэхдээ зүгээр Төв банкны манай статистик, бидний гаднын хөрөнгө оруулагч болон банкнууд бүх л судлаач эдийн засагтай хийсэн уулзалтаар яг энэ 23 оны 12 сарын 31-ээр ингээд хугацааны хязгаараар хэрэгжихэд их төвөгтэй байгаад байгаа юм. Төвөгтэй шалтгаан нь юу байна вэ гэхлээр арилжааны банкнууд сая 5 том банк 5-10 хувиа олон нийтэд хувьцаа болгож зарсан, 473 тэрбум төгрөг босгосон.

Тэгэхлээр 5-10-хан хувиа одоо арилжаалахад 400-гаад, бараг 500-гаад тэрбум төгрөгийн ийм эх үүсвэр босож ирж байгаа юм. Тэгэхлээр өнөөдөр зарим хувьцаа эзэмшигч нь 50 хувьтай, зарим хувьцаа эзэмшигч нь 30 хувьтай ч юм уу ингээд өндөр хувьцаа, төвлөрөлтэй байгаа энэ улсууд өөрийнхөө хувьцааг зарахад одоо бараг тэр 10 хувь дээрээ л бараг 500 тэрбум төгрөг босгохоор ингэж байгаа учраас бол энэ өөрөө хөрөнгийн биржээс босгох ийм боломжтой хөрөнгө гэж харагдахгүй, нэгдүгээрт харагдахгүй байгаад байгаа юм. Нэг дэх нь. Яах вэ Банкны тухай хуулийн өөр нэг хуулийн заалтаар бол хэрвээ энэ 12 сарын 31-нээрээ хатуу яваад энэ 20 хувь дээр орж чадахгүй бол одоо 20-оос илүү гарсан хэсгийнх нь хувьцааны саналын эрхийг түдгэлзүүлэхээр манай хуулийн өөр нэг заалт байдаг л даа. Тэр заалтын дагуу Монголбанк бол хатуу арга хэмжээ аваад явах боломж нь байгаа.

Гэхдээ бас нэг төвөгтэй зүйл үүсэх магадлал нь удирдлага, банкны удирдлагын зохистой засаглалд хямрал үүсэх магадлалтай. Яагаад гэвэл тэнд 1 хувьцааных нь төвлөрлийг нь бууруулах гээд 1 хүний саналын эрхийг хасаад ирэхлээр эргээд засаглалын хямрал гарах ийм эрсдэл бас байна гэж хараад байгаа юм. Тэр утгаараа ер нь бол энэ 12 сарын 31-ний энэ хугацааг хойш нь бас жил юм уу, 2 жилээр сунгавал зөв болов уу л гэсэн л ийм л саналыг л бас ярьж байгаа юм. Тийм.

**Ц.Цэрэнпунцаг:** Ажлын хэсгээс гүйцээж хариулъя. Ажлын хэсгийн 1 номер Ган-Очир хариулъя.

**Д.Ган-Очир:** Ганбаатар гишүүний асуултад хариулъя. Зээлийн жигнэсэн дундаж хүү арилжааны банкны хувьд бол 16-16.5 хувийн хооронд сүүлийн саруудад бол хэлбэлзэж байгаа. Бизнесийн зээлийн хүү мэдээж бизнесийнхээ онцлог салбарууд болон яг зээлдэгч аж ахуйн нэгжийн санхүүгийн үзүүлэлтээсээ уялдаад бол ялгаатай



тогтдог. Яг жигнэсэн дундаж нь бол 16, 18 хувийн хүүтэй байна. Хэрэглээний зээл ч гэсэн бас харилцагч болгоноороо ялгаатай.

Гэхдээ жигнэсэн дундаж нь бол 19.5-20 хувьтай гэдэг ийм статистик бидэнд одоо байна. Тийм.

**Ц.Цэрэнпунцаг:** Ганбаатар сайд нэмж асуулт асууя. Тодруулж асууж асууя.

**Ж.Ганбаатар:** Үгүй ээ, Энэ нөгөө нээлттэй болоход чинь бас л энэ одоо хүрэхгүй, хүрнэ, эдийн засаг дийлнэ, дийлэхгүй гээд л намайг Эдийн засгийн байнгын хорооны дарга байхад тэгээд л нээлттэй болсон шүү дээ. Та өөрөө ийм эргэлзсэн байр суурьтай болохлоор хэн одоо хууль биелүүлэх вэ дээ. Тэгээд л одоо хууль биелүүлэхгүй. Одоо тэгээд л хойшлуулах байр суурьтай байна гэдэг чинь өөрөө одоо ингээд л бүгдээрээ л тэгж тэгж ойлгочихсон. Энэ чинь онцгой салбар шүү дээ. Хүмүүсийн мөнгө аваад эргэлдүүлж байгаа онцгой салбар түүнээс зөвхөн өөрийнхөө мөнгийг эргэлдүүлж байгаа бол одоо тэр яах нь өөрийнх нь асуудал шүү дээ. Тэгэхлээр онцгой салбар дээр онцгой хуультай байх нь ойлгомжтой. Тэгэхлээр энийг бол одоо шинэчлэлээсээ хойшоо ухарч байна шүү дээ. Арай л байна л даа. Тэгээд л нэг тийм найрсаг байдалтай. Та тэгээд наад жигнэсэн дундажаа аятайхан ярихгүй бол 18 хувьтай хэн ч зээл авахгүй байгаа шүү.

**Ц.Цэрэнпунцаг:** Ажлын хэсэг 3 номер нэмж хариулах уу.

**Б.Лхагвасүрэн:** Ганбаатар гишүүний асуултад нэмж тодруулъя. Анх энэ 21 онд орж байгаа энэ хуулийн зарчмын энэ 2 том өөрчлөлтийг оруулж ирэхдээ Монголбанкны анхны төсөл, судалгаа бол юу гэж байсан гэхлээр ийм томоохон ийм банкны секторын энэ бүтцийн өөрчлөлтийг ерөнхийдөө дунджаар 5-8 жилийн хугацаанд хийдэг юм байна. Тийм учраас одоо IPO хийх энэ

5 банкиг зэрэг ингээд оруулж байгаа энэ юмаа хүртэл жоохон хугацаатай, 20 хувьд оруулж байгаагаа ч гэсэн бас тодорхой хугацааны ийм юутай байхгүй бол олон улсын туршлага нь бол өөрөө ийм 5-8 жил байдаг юм гэдгээрээ судалгаа оруулсан. Тэгээд 3 жилийн дотор багтааж хийе гэдгээрээ л хууль өөрөө гарч ирсэн учраас бас одоо ингээд л шахагдаад л явж байгаа байх. Тэрнээс биш яг Монголбанкны зүгээс энийг хэрэгжүүлэхгүй ч гэдэг юм уу энэнээс нь ухарч байгаа зүйл байхгүй. Биднүүс бол хэрэгжүүлээд л, зүтгүүлээд л явна. Ганцхан одоо энэ хэрэгжүүлэх явцад гарч ирэх бас ийм эрсдэл, тийм тийм эрсдэлтэй. Хамгийн гол нь тэнд.

**Ц.Цэрэнпунцаг:** Гишүүд асуулт асууж, хариулж дууслаа. Ингээд та бүхэнд тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгээ явуулах үед хуралдаан даргалагчаас гүйцээн боловсруулах, байхгүй байхгүй. Гүйцээн боловсруулах чиглэл өгч, санал хураалгаагүй. Ингээд нээлттэй үлдээсэн саналаар санал хураалт явуулъя. Саналын томъёоллыг та бүхэндээ уншиж танилцуулъя.

Тогтоолын төсөлд доор дурдсан агуулгатай 2 дахь заалт нэмэх:

“2.Доор дурдсан арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар /Л.Оюун-Эрдэнэ/, Монголбанк /Б.Лхагвасүрэн/, Санхүүгийн зохицуулах хороо /Д.Баярсайхан/-нд тус тус даалгасугай:

1/Орон сууцны ипотекийн хөтөлбөрийг Засгийн газар шилжүүлэн авах хүртэлх хугацаанд хөтөлбөрийн тасралтгүй байдлыг хангаж, зээлийн эргэн төлөлтөөс санхүүжүүлэх;

2/Орон сууцны ипотекийн хөтөлбөрийн хүрээнд олгох зээлийн нийт эх үүсвэрийг нийслэл, орон нутагт тэгш, хүртээмжтэй хуваарилах. Санал гаргасан ажлын хэсэг. Энэ томъёоллоор байхгүй байгаа. Саяын уншсан саналын томъёоллоор санал хураалт явуулъя.

*Санал хураалт. Тэгш, хүртээмжтэй гэсэн.*

*Гишүүдийн 70 хувь нь дэмжиж, санал дэмжигдлээ. “Төрөөс мөнгөний бодлогын талаар 2024 онд баримтлах үндсэн чиглэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн эцсийн хэлэлцүүлгийг хийж дууслаа. Тогтоолын төслийн эцсийн хэлэлцүүлгийг хийсэн талаарх Байнгын хорооны танилцуулгыг чуулганы нэгдсэн хуралдаанд, та байх билүү. Улсын Их Хурлын гишүүн Ч.Ундрам уншиж танилцуулна.*

*Эдийн засгийн байнгын хорооны өнөөдрийн хэлэлцэх асуудал дуусаж, хуралдаан үүгээр өндөрлөж байна.*

*Хуралдаанд идэвхтэй оролцсон гишүүд та бүхэндээ баярлалаа. Ажлын хэсгийнхэнд бас баярлалаа.*

*15.13 цаг*

*ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ  
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ  
БУУЛГАЖ ХЯНАСАН:  
ШИНЖЭЭЧ Д.ОТГОНДЭЛГЭР*